

“ГЕРМЕНЕВТИК ТОЙРОГ”- ИЙН ЗАРЧИМ БА ОЙЛГОХУЙН АСУУДАЛ

Б.Дуламсүрэн - БХИС-ийн нийгэм - хүмүүнлэгийн тэнхимийн багш, докторант

Түлхүүр үг: “герменевтик тойрог”, бичвэр, “эртний үеийн оюун сэтгэлгээ”, бүхэл, хэсэг, ойлгохуйн гурван хэлбэр, утга холбогдол, интуитив ойлгохуй,

Товч утга: Бүхэл, хэсэг хоёрын хоорондын харилцан үйлчилгээ, харилцааг тусгасан герменевтик тойргийн ухагдахууныг герменевтикийн түүхэнд хэрхэн авч үзэж ирснийг энд үгүүлнэ.

“Герменевтик тойрог”-ийн ойлголт нь ойлгохуйн ерөнхий онол болох герменевтикийн үүсэл хөгжилтэй холбоотой урт удаан түүхтэй билээ. Шидэт домгийн дүүрүүд болон хожим нь эртний бичвэр, түүхэн баримтыг тайлбарлах зайлшгүй шаардлага нь тайлбарлахуйн тусгай зарчим болон аргын янз бүрийн эрэл хайгуул хийхэд хүргэж байв. Цаашдаа эдгээр зарчим аргууд, түүний дотор “герменевтик тойргийн” зарчмыг герменевтик шинжилгээ хийгчид бараг бүгдээрээ хэрэглэжээ. Гэхдээ “герменевтик тойрог” нь XIX зууны дунд үед л философийн герменевтикийн арга зүйн тулгуур ойлголт болсон юм. Бичвэрийг тайлбарлахад урсгалаар хэрэглэгдэж байсан “герменевтик тойргийн” зарчим нь ойлгохуйн үйл явцын тодорхой схем хийх оролдлоготой холбоотойгоор онолын утга холбогдолтой болжээ.

“Герменевтик тойргийн” ойлголт нь герменевтикийг хэл шинжлэлийн аль нэг салбар биш харин ойлгохуйн ерөнхий онол гэж анх тодорхойлсон Фридрих Шлейермахерын бүтээлүүдэд өргөн тусгагдсан төдийгүй нэлээд гол байр суурийг эзэлдэг. Гэхдээ “герменевтик тойргийн” санаа бүр Фр.Астын бүтээлд томъёологдсон бөгөөд Шлейермахер онолдоо авч хэрэглэсэн гэдгийг зайлшгүй тэмдэглэх хэрэгтэй.⁶⁹

Германы нэрт хэл шинжээч Фридрих Аст эртний грекийн соёлыг судалж байсан билээ. Тэрээр эртний зохиолчдын утга зохиолын өвд илүү тодорхой илэрхийлэгддэг гэж үзэж “эртний үеийн оюун сэтгэлгээг” ойлгож ухаарахыг эрмэлзэж байв. Тоосонд дарагдсан гар бичмэлүүд болон хэл зүйн хоосон ёсорхол бол хэл шинжлэлийн зорилго байх ёсгүй, гэхдээ зөвхөн зохиолын гадаад дотоод агуулгын нэгдлийг ойлгох арга хэрэгсэл байх ёстой гэж тэрээр бичжээ. “Эртний үе бол уран сайхны болон шинжлэх ухааны соёлын төдийгүй бүхий л амьдралын үлгэр загвар болох” учраас “эртний үеийн оюун сэтгэлгээг” ойлгох нь грекүүдтэй адилхан болно гэсэн үг юм.⁷⁰ Гэвч “эртний үеийн оюун сэтгэлгээ” нь хэлнээс ангид ойлгогдох учиргүй. Хэл бол оюун сэтгэлгээг дамжуулах анхдагч орчин болно. Гэтэл хэлийг ойлгохын тулд бид хэл зүйгээр гачигддаг. Үүнээс гадна эртний зохиолчдыг унших нь уншигч хүнд уншсан зүйлдээ зөв тохирох дүгнэлт хийн тайлбарлаж чадах зарим суурь зарчим шаардагддаг. Чухамхүү ийм учраас “эртний хэлнүүдийг судлах нь герменевтиктэй

⁶⁹ Гегель “Феноменология духа” зохиолдоо Кантаг шүүмжилж: үнэн мэдлэгийг зөвхөн тэр мөшгөх онолыг танин мэдэж байж л олж авч болно, харин үүнийг үнэн мэдлэг олж авах үйл явцад хүргэж болохгүй, өөрөөр хэлбэл танин мэдэхүйд бүхэлд нь хамаатуулж болохгүй гэж хэрэг дээрээ “герменевтик тойргийг” ашигласныг орчин үеийн герменевтикчид эш үндэс болгодог нь үнэн билээ. Харин Гегель энэ хоёр үйл явцыг нэгтгэж гэхдээ герменевтиктэй холбож байгаагүй юм.

⁷⁰ Palmer K. Hermeneutics. Evanston, 1969.p.76

ямагт холбогдох ёстой” гэж Аст дүгнэжээ⁷¹. Энд герменевтик нь хэл зүйгээс ялгагдаж бичвэрээс оюуны утга учрыг гаргаж авах онол хэмээн тайлбарлагдаж байна.

Эртний зохиолчдыг судлах, зохиолыг нь илүү бүрэн дүүрэн ойлгох судалгааны ажлын зорилгыг хараад Аст ойлгохуйн үйл явцыг оюуны ямар нэг нэгдмэл эхлэлийг ойлгохуй юм гэж үзжээ. Түүний бодлоор, урлагийн бүтээлүүдэд (эсвэл судлагдаж буй бичвэрүүдэд) шингэсэн (хэрэгжсэн) оюуны эхлэл нь өөр оюунаар буюу тайлбарлагчийн ухаанаар ойлгогдсоны үр дүнд ойлгохуй хэрэгждэг ажээ Оюуны зүйл нь ямагт дотооддоо нэгдэлтэй байдаг учраас судалж буй бүтээлийн зохиогчийн төдийгүй амьдарч байсан эрин үеийнх нь оюуны дотоод амьдралыг ойлгох хамгийн гүнзгий үндэс болдог байна.

Оюуны нэгдлийн үзэл санаа нь Астын “герменевтик тойргийн” зарчмын үндэс юм. “Оюун сэтгэхүй нь бүхий л амьдралын фокус, байнга хэлбэржүүлэгч зарчим” учраас янз бүрийн хэсгүүдэд илэрхийлэгдэж аливаа зүйлийн бүрэлдэх, хөгжих эх сурвалж болно⁷². Гэхдээ хэсгүүд нь бүхлээр, харин бүхэл нь хэсгүүдийн дотоод зохицлоор ойлгогдоно. Жишээлбэл, зохиолыг бүхэлд нь ойлгохуй бол түүний хэсгүүдийн дотоод утга, өөр хоорондоо болон илүү өргөн “эрин зууны оюун санаанд” хэрхэн харилцаж буйг тайлбарлахад оршино. Эртний үеийн тухайд Астын үзэж буйгаар “эртний үеийн оюун санааны” тусгай тусгай илрэлүүд бүхий тодорхой зохиолуудыг ойлгосноор л бүхэл нэгдлээр нь тайлбарлах боломжтой. Нөгөө талаас зохиогчийн хувийн онцлог, давтагдашгүй чанарыг бүхэл буюу эрин үеийн оюуны амьдралтай нягт холбоотой авч үзэхээс өөр аргагүй.

Ийнхүү ойлгохуйн үйл явцын дүр зургийг тодорхойлохдоо Аст “герменевтик тойргийн” зарчмыг “хэсэг – бүхэл” гэсэн хувилбараар ашиглажээ. Хэдийгээр энэ ойлголт Астын үзэл баримтлалд байгаа боловч нарийн тодорхойлолтгүй бөгөөд хэрэг дээрээ тийм ч тодорхой бус юм. Хэл шинжээчид герменевтикийн зорилтыг судлагдаж буй объектыг тайлбарлахад оршино гээд ойлгохуйн боломжит гурван хэлбэрийг авч үздэг. Үүнд: түүхийн (зохиолын агуулгыг ойлгох), хэл зүйн (хэлийг ойлгох), оюуны (эрин үеийн “оюуныг” бүхэлд нь ойлгох замаар зохиогчийн үзлийг бүхэлд нь ойлгох) ойлгохуй юм. Эхний хоёр хэлбэр нь эртнээс тодорхой бөгөөд өмнө нь хөгжжээ. Гурав дахь, герменевтик ойлгохуйн оюуны хэлбэрийг Аст боловсруулж түүний залгамжлагчид, зарим талаар Шлейермахер цааш хөгжүүлжээ.

Шлейермахер ойлгохуйн үйл явцыг бичвэрийн зохиогчийн оюун сэтгэхүйн үйл явцыг өвөрмөцөөр дахин ухаарах урлаг гэж тодорхойлсон. Тэрээр бүхэл бичвэрийн бүтцийн өнгөц тоймоос эхэлж зохиолын зохиомжид нэвтрэхэд хүргэж буй хэсгүүд рүү сэтгэхүйгээр шилжиж байна. Зөвхөн үүний дараа л тайлбарлахуй жинхэнэ эхэлнэ. Тийм маягаар тайлбарлахуй нь “хэл зүйн”, “сэтгэл зүйн” гэсэн хоорондоо холбоотой хоёр үйл явцаас бүрдэнэ. Энд өргөн утгаар “сэтгэл зүйн” гэдгийн дор Шлейермахер бичвэрт тусгагдсан зохиогчийн дотоод амьдралыг илэрхийлж буй зүйлийг ойлгож байна.

Энэ сэргээн дүрслэлт (“хэл зүйн” болон “сэтгэл зүйн”) нь “герменевтик тойрог” дээр үндэслэгдэнэ. Шлейермахерийн үзлээр ойлгохуй бол харьцуулах буюу адилтгахтай холбоотой суурь үйл явц юм. Энэ нь аль хэдийн тодорхой болсон зүйлтэй харьцуулна гэсэн үг. Бидний ойлгож байгаа зүйл нь өөрөө зарим нэгдлийг бий болгодог, өөрөөр

⁷¹ Мөн тэнд.

⁷² Palmer K. Hermeneutics. Evanston, 1969.p.77

хэлбэл хэсгүүдээс бүрсэн бүхэл “тойргийг” бүрдүүлдэг байна. Тойрог нь бүхлийн хувьд тусгай хэсгүүдээ тодорхойлж энэ хэсгүүд нь хамтдаа тойргийг бүрдүүлж байдаг.

Хоорондоо холбоотой хэсгүүдээс бүрдэж буй бичвэрийн эгэл нэгжийн жишээ нь өгүүлбэр юм. Үг бол ямагт нэг утгатай байдаггүй нь тодорхой. Үг нь эх бичгээс, өөрөөр хэлбэл бүхий л өгүүлбэртэй хамааралтайгаар утгын ямар нэгэн ялгаатай болно. Нөгөө талаас өгүүлбэрийн утгыг ойлгохуй нь бүхлийн хувьд түүнийг бүрдүүлж буй тусгаар үгийн (хэсгийн) утгыг ойлгохуйгаас хамаарна. Хэсэг ба бүхлийн холбооны ачаар дараалсан үг тус бүр нь өмнөхдөө утга оруулан бүхий л өгүүлбэрийн утгыг тодруулдаг, эсвэл эсрэгээр байдаг. Ойлгохуйн үйл явц энэхүү өвөрмөц тойргоор явагддаг учраас Шлейермахер түүнийг герменевтикийн⁷³ гэж нэрлэжээ.

Хожим нь В.Дильтей Шлейермахерийн философийн үзэл, “герменевтик тойргийн” ойлголтыг тодорхойлж: “Бүхэл нь тусгаар хэсгийн ухагдахуунуудад, тусгаар хэсгүүд нь бүхлийнхээ ухагдахуунуудад ойлгогдох ёстой. Зохиолыг ойлгохын тулд бид зохиогчид болон түүний төрөл утга зохиолд хандах ёстой. Ийм харьцуулах үйл явц нь тусгаар өгүүлбэр бүрийг өмнөхөөс илүү гүнзгий ойлгох боломж өгнө. Ийм учраас бүхэл болон түүний тусгаар хэсгүүдийг ойлгох нь харилцан холбоотой”⁷⁴ гэжээ.

Эхлээд харахад “герменевтик тойргийн” ойлголт нь формаль логикийн зөрчилтэй мэт санагдана. Хэрэг дээрээ хэрэв хэсгийг ойлгохоосоо өмнө бүхлийг ойлгох ёстой бол бид хэзээ ч, юуг ч ойлгохгүй. Гэхдээ бид өмнө нь хэсгүүд утгаа бүхлээс авдаг, мөн тэр үед хэсэгт ялгараагүй бүхлээс эхэлж чадахгүй гэж баталж байсан. “Герменевтик тойргийн” ойлголт нь огт үндэслэлгүй юм биш үү? гэсэн асуулт зүй ёсоор гарч ирнэ. – Үгүй ээ, формаль логик бол ойлгохуйн ажлыг бүрэн тайлбарлаж чадахгүй гэж бид хэлэх ёстой хэмээн герменевтикч хариулна. Энэ үйл явцын аль үе шатанд “герменевтик тойрогт орох”, “тойргоос гарах” үйл явц болдог тухайд бид бүхэл ба хэсгийг хамтад нь ойлгоно.

Шлейермахер герменевтик тойргийн зарчмын тухай тайлбартаа ойлгохуйн үйл явцыг зарим талаар харьцангуй – хэл зүйн, зарим талаар интуитив хэмээн тодорхойлж интуицид өргөн зам нээж өгчээ. Харилцаанд энэ нь диалоги харилцаа болдог учраас бүр эхнээсээ л яригч ба сонсогчдын хуваалцдаг утга холбогдлын нийтлэг болж өгнө. Мөн энэ нь хэлний болон хэлэлцэгдэж буй юмны тухай мэдлэг болж өгнө. Өгүүлбэрээр авсан жишээний адил энд ч зөрчил илэрч байна: ойлгох ёстой зүйл нь аль хэдийн тодорхой болчихсон зүйл байх ёстой. Хэлний түвшинд ч (хэлэлцүүлгийн орчин), юмсын түвшинд ч (хэлэлцүүлгийн материал) бид юуг хэлэлцэх гэж байгаа тухай ямар нэг хэмжээний мэдлэг байх ёстой. Энэ байх мэдлэгийг Шлейермахер доод угтвар мэдлэг буюу угтвар ойлгохуй гэж нэрлэсэн байна. Чухамхүү үүний ачаар “герменевтик тойрогт үсэрч орох” нь хэрэгжих бөгөөд тэр хэрээр зөрчил шийдвэрлэгддэг байна. Ийнхүү ойлгохуйн үйл явцыг бичвэрийн тайлбартай төдийгүй хүмүүсийн амьд харилцан яриатай холбосноороо Шлейермахер өмнөх үеийнхнээс илүү тодорхой зураглал гаргажээ.

Герменевтик тойргийн дотор байгаа бүрэн ойлгохуй нь интуицийн үйлчилгээгээр, мөн харьцуулах аргад тулгуурласан субъектив анализын тусламжтайгаар урагшилдаг. Энд тодорхойлогч үе нь “угтвар ойлгохуй” бөгөөд “герменевтик тойргийн” зарчмыг тайлбарлахдаа Шлейермахер чухам үүнд л найджээ.

⁷³ Schleiermacher F.D.E .Hermeneutik. Heidelberg, 1969.p.166

⁷⁴ Dilthey W. Selected Writings. L., 1976.p.262

“Герменевтик тойргийн” доторх ойлгохуйн үйл явцыг Дильтей шинжилж цааш хөгжүүлжээ. Бүхэл ба хэсгийн харилцан үйлчлэлийн хамгийн энгийн жишээ болгож өгүүлбэрийг авч үзээд тэрээр утга холбогдлыг энэ харилцан үйлчлэлийн үр дүнд л бий болдог зүйл гэж ялгажээ. Тусгаар хэсгүүдийн утга нь бичигдсэн, ухаарагдсан схем дэх өгүүлбэрийн үгийн тодорхойгүй байдлыг тодруулж, заримдаа сольж байдаг бүхлийн утгыг ойлгох явдлыг хангаж өгдөг. Бүхлийн утга нь тусгаар хэсгүүдийн утгаас гаргаж авсан “утга санааг” бүрдүүлнэ. “Герменевтик тойргийн” зарчим нь энд арга зүйн чухал тал болж байна. Тэр нь дахиад л нийлмэл бүхэл болон түүний хэсгүүдийг ойлгоход гарч ирнэ. “Энэ утгаар бид аливаа тайлбарлахуйн ерөнхий бэрхшээлтэй тулгардаг: бүхэл өгүүлбэр нь тусгаар үгс болон тэдгээрийн зохицлоос ойлгогдох ёстой бөгөөд бүхлийг ойлгохуй нь тусгаар хэсгүүдийг бүрэн дүүрэн ойлгохуйг нөхцөлдүүлж өгдөг” гэж Дильтей⁷⁵ бичжээ.

Аливаа тохиолдолд тойрог нь зохиогчийн оюуны хөгжлийг тусгасан тодорхой зохиолтой харьцахад ямагт давтагдах бөгөөд түүний зохиол бүтээлд бүхэлд нь харьцахад дахин буцдаг.

Дильтейн герменевтикт хандах байдлыг хоёр шалтгаанаар тайлбарлаж болно. (хэдийгээр Дильтей бүр эхнээсээ л герменевтик үзэл баримтлалтай байсан гэх өөр үзэл байдаг боловч). Нэгдүгээрт, Шлейермахерын герменевтикээр батлагдсан сэтгэл зүйн чиглэлийн хүрээнээс гаргах гэсэн эрмэлзлээр; хоёрдугаарт, Дильтейн үзлээр эхний болоод төгсгөлийн пункт нь түүхэн тодорхой, амьд туршлага болдог оюун сэтгэхүйн тухай шинжлэх ухаануудыг үндэслэх арга зүйн баазыг эрж хайх явдлаар гэж үзэж болох юм. “Амьдрал бол амьд туршлага” – энэ бол Дильтейн бүхий л философийн голт зүрх болсон илэрхийлэл боловч герменевтик чиглэлийн шинжийг шууд тусгаагүй юм.

“Амьдрал”-аас бид сэтгэхүйгээ хөгжүүлж, түүнд асуултаа тавьж байдаг. Амьдралыг бид байгалийн шинжлэлийн ухагдахуунуудаар (“масс”, “хүч” гэх мэт) хүлээн авч мэдэрдэггүй, харин хэсгийн ойлголтуудаар дамжуулан түгээмэл амьд туршлага дээр, дахин давтагдах чанар дээр мэдэрдэг.

Дотоод амьдралын динамик нь мэдрэмж, зориг, танин мэдэхүйн нарийн нийлмэл мөн чанартай учраас байгалийн шинжлэх ухаан шиг механикийн болон тоон логикт захирагддаггүй. Бүрэн дүүрэн амьд туршлагад эргэж очно гэдэг нь амьдралыг өөрийг нь ойлгоно гэсэн үг. Бид өөрсдийгөө ойлгоход бүрэн хангалттай зүйл өгдөг түүх бол амьдралыг ойлгоход бусдаас хамгийн ойрхон юм. Тэгэхдээ ойлгохуй нь аливаа судалгааны суурь болохын хувьд герменевтикийн аргаар л хэрэгжинэ.

Ойлгохуй нь бичвэрт хэсэг ба бүхлийн харилцан үйлчлэлээр явагддагийн адил Дильтейн үзлээр “амьдралд” жишээ нь өнгөрсөн ба одоогийн харьцаа ажиглагддаг ба тэдгээрийн харилцан үйлдэл нь тойргийг бүрдүүлж түүн дотор “амьдралын өөрийнх нь” түвшинд ойлгохуй ч хэрэгждэг байна. Хэрвээ “герменевтик тойргийн” ерөнхий зарчим нь ойлгохуйн аргын хатуу, тогтонги байдалд чиглэдэг бол ойлгохуйн агуулга, утга санаа нь байнгын өөрчлөлт, хэлбэлзэлд өртөж байдаг. Үйл явдал, туршлага нь өмнө ойлгогдсон гэж тооцогдож байсан зүйлийг юу ч биш болгож, эсвэл эсрэгээр буруу худал мэт санагдаж байсан туршлагыг өөрчилж утга холбогдлыг нь эргэж харах хүртэл өөрчилж чадна.

Хэсэг ба бүхлийн харилцан үйлдлийн үр дүн болох “утга холбогдлыг” зөвхөн тухайн үзэл баримтлалын үүднээс, тухайн цаг хугацаанд, түүхэн нөхцлийн тухайн тохиолдолд л

⁷⁵ Dilthey W. Selected Writings. L., 1976. p.259

авч үзэж болно гэж тэрээр баталж байна. Утга холбогдол нь хөдөлгөөнгүй тодорхойлолтоор бичигдэхгүй, учир нь тохиолдол бүрт тайлбарлагч маш олон янзаар тодотгож байдаг. Утга холбогдол нь тайлбарлагчийн өөрийнх нь оршиж буй тэр нөхцөл байдлын хэсгийг бүрдүүлж эх бичвэрээс гарч ирэх ба цаг хугацаанд түүхэн ёсоор өөчлөгдөж байдаг.

“Утга холбогдол нь хэсэг бүхлийн харилцаанд суурилан үүснэ, өөрөөр хэлбэл амьд туршлагын мөн чанар дээр үндэслэнэ” гэж Дильтей бичжээ⁷⁶. Өөрөөр хэлбэл бичвэр нь үзэж мэдрэхүйн зөвхөн нөхцөл, эх сурвалж болдогийн адил утга холбогдол нь субъект – тайлбарлагчийн амьд туршлагад, “амьдралын нэхээсэнд” дотоод шалтгаан болно. Үүний хамт ойлгохуйн үйл явцын зорилт нь улам нарийн түвэгтэй болж, хэрэг дээрээ субъективчлагддаг байна. Дильтейн хувьд “герменевтик тойрог” нь тодорхой бичвэр, тодорхой тайлбарлагч хоёрын дунд тухай бүр шинээр тогтоогдож байх болж байна. Энэ үед тайлбарлагч нь өөрийн багтдаг амьдралын, түүхэн туршлага ба бичвэрийн эргэцүүлж буй зүйл (бичвэрт зөнгөөрөө орж, хэрэг дээрээ өөрөө өөртөө орж) хоёрын хооронд өвөрмөц **зууч** болно.

Ийнхүү Дильтейн хувьд бичвэрийг ойлгох цэвэр хэл шинжлэлийн арга нь түүхийн судалгааны иррационалист арга зүйд хувирч, түүнчлэн “герменевтик тойргийн” зарчимд шилжин маш өргөн утга холбогдолтой болжээ. Тэрээр уг зарчмыг субъектив үйл ажиллагаанаас урган гарч ирдэг нийгэм – түүхийн бодит байдал дээр тулгуурласан түүхийг ойлгох арга зүйн чухал тал болгож төгөлдөржүүлсэн юм.

Дильтейн үзэл баримтлалд “герменевтик тойрог” нь түүхэн янз бүрийн соёл (амьдралын хэв маяг) болон нэг бол энэ янз бүрийн соёлд орохыг эрмэлздэг, эсвэл тэдгээрт өөрийн хувийн тогтворгүй агуулгыг нэмж оруулдаг тайлбарлагчийн хувирамтгай байр суурийн хоорондын хөдөлгөөний төрөл болдог. Ийм учраас “герменевтик тойргийн” хүрээнд явагдаж байгаа ойлгохуй нь өөрөө “ямагт харьцангуй бөгөөд хэзээ ч төгс болж чадахгүй”⁷⁷. Тэр нь түүхэн үзлийн хаяалбарыг байнга өргөтгөж өөрчлөн хувиргаж байдаг.

Дильтейн герменевтик үзлийг залгамжлагч оросын Г.Шпет бол феноменологич философичдоос анх удаа түүхийн асуудлыг анхаарлын төвд тавьсан гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Түүхийн шинжлэх ухааныг тэрээр “үгийг утга холбогдолд нь унших” гэж ойлгож байсан учраас түүхийн үндэс нь герменевтик уламжлалаар авч үзэж тайлбарлах асуудал болж байна⁷⁸. Шпетийн хувьд “герменевтик тойрог” нь тайлбарлагч-субъект ба “түүхийн” харилцаа байдаг.

“Герменевтик тойргийн” зарчмыг иррациональ байдлаар тайлбарлах замд М.Хайдеггер бол Дильтейгээс бүр цааш явсан юм: “Герменевтик тойрог” нь алдаатай төдийгүй харамсалтай, гэхдээ зайлшгүй ёс журмын гэдгээр ч зогсохгүй юм. Харин эсрэгээр түүнд танин мэдэхүйн илүү анхдагч хэлбэрийн эерэг боломж нуугдаж байдаг... Бидний эхний бөгөөд эцсийн, байнгын зорилго нь танин мэдэхүйн урьдач нөхцлийг бодож олох биш, өмнө нь бэлэн байгаа үзэл баримтлалуудаар орлуулах ч биш, харин танин

⁷⁶ Dilthey W. Gesammelte Schriften. B d. VII. — Gxttingen, 1968.p.347

⁷⁷ Dilthey W. Selected Wrightings. p.259

⁷⁸ Шпет Г.Г. Внутренняя форма слова. М., 1927.с.38;
Мөн түүний История как проблема логики. М., 1916.с.23

мэдэхүйн эдгээр урьдач бүтцүүдийг юмсын өөрийн нь ухагдахуунаар боловсруулах явдал гэдгийг бүрэн ухамсарласан үедээ л энэ боломжийг олж авна⁷⁹.

Эш татсан хэсгээс үзвэл Хайдеггер “герменевтик тойрогт” онтологи утга оруулж байна. Уг чанартаа түүнд аливаа шинжлэх ухаан – танин мэдэхүйн баримт тусгалаа олдог билээ. “Герменевтик тойргийн” зарчмын онтологи утгын тухай дүгнэлтийг Хайдеггер судалгааны субъект объектын харилцааны харилцан нөхцөлдүүлэлтийн баталгааны үндсэн дээр хийсэн юм. Хайдеггерийн “ойлгохуй” хэмээх ухагдахуун нь дотоод хүч мэт, онтологи утгатай ахуйн гүнд нуугдаж буй зүйлийг мэдрэх чадвар, ахуйлаг байдлын уг–үндсийг заадаг, тухайн дүрийн субъектив сэтгэл хөдлөлийн урсгалд угтвар мэдрэмжийн үүднээс тойргоор нөлөөлдөг мэтээр тайлбарлагддаг нь ийм онтологи үзлийн онцлог юм.

Бидний харснаар Дильтей ойлгохуйг “дотоод бодит байдлын” нийгэм-сэтгэл зүйн илэрхийллийг “барьж авах” агшныг өөртөө багтаасан ухаарахуйн гүнзгий түвшинд хамааруулжээ.

Хайдеггерийн хувьд ойлгохуй нь “амьдралын ертөнцийн” хүрээн дэх ахуйн хувийн боломжийг ухаарахуйн хүчинд оршдог байна. Хайдеггер ойлгохуйг ахуйн гүнд нэвтрэхийг эрмэлзсэн хүний ухамсрын оршихуйн бүтцийн элемент буюу модус мөн, гэхдээ түүнийг эзэмшихгүй гэж үзжээ. Ойлгохуйн агуулга бол ертөнцийн объект биш гэхдээ ахуйн өөрийн төсөөлөгдөх бүтэц юм. Ойлгохуй нь аливаа тайлбарлахуйн суурь бөгөөд ийм учраас өөрийн агуулгаар дамжуулан оршихуйн акт бүртэй харьцуулахад анхдагч онтологи үндэс болдог. Хайдеггерийн хувьд ойлгохуйн хоёр дахь тал нь ямагт ирээдүйд хамаарч төслийн, урьдчилсан таамаглалын шинжтэй байдаг. Ойлгохуйн аливаа акт бол “төсөл”, шууд өгөгдсөн утгын хүрээнээс гарах нь ахуйн цаашдын хандлагын хэлбэр болно.

Хайдеггерийн үзлээр, ойлгохуйн мөн чанар нь нөхцөл байдлыг зүгээр л ухаарахад төдийгүй, харин ахуйн боломжуудыг нээхэд оршино. Ойлгохуйн акт нь ямагт “герменевтик тойргийн” хүрээнд, ахуйд нэвтрэн орох гэсэн хүний оршихуйн эрмэлзлийн хүрээнд, энэ оршихуйд үзүүлэх ахуйн нөлөөний хүрээнд хэрэгжинэ. Түүний үзлээр тухайн тойрог нь мэдлэгийг түүний объектой, түүхэн мэдлэгийг түүхэн ахуйтай салшгүй холбож өгөх ёстой. Хайдеггерийн герменевтик нь феноменологи-субъектив, гэхдээ ер нь онтологи шинжтэй, хүн төрөлхтний аливаа ойлгохуй ба тайлбарлахуйн онтологи бүтцийн тухайд “герменевтик тойргийн” феноменологи үр дагаврыг судалдаг юм.

Хайдеггерийнхаар ертөнцийн ахуй нь ярианд байдгаас илүү баялаг, бүрэн дүүрнээр хэлэнд илэрдэг. Хэлний энэ нуугдмал хэсэг нь өөртөө ойлгохуйн ямар нэг угтал-феноменыг агуулж байдаг. Хэлний ачаар ертөнц, түүний объектив ахуйг ойлгох боломж бүрдэнэ. Түүнээс гадна хэл бол ахуй өөрөө мөн учраас чухамхүү хэлэнд л философи голлон анхаарах ёстой гэж Хайдеггер баталж байна. “Хожмын” Хайдеггер нь герменевтикт экзистенциал философийн статус олгож түүний хамт “герменевтик тойргийн” зарчим нь танин мэдэхүйн аливаа баримтын бүтцийг тодорхойлох болжээ. Эцсийн дүндээ түүний системд тойрог нь дараах бүтэцтэй болов. Үүнд: ахуйн ойлгохуй нь түүний тайлбарлахуйг нөхцөлдүүлнэ (ойлгоогүй зүйлийг тайлбарлахгүй), гэхдээ ахуйн тайлбарлахуй нь зөвхөн интуитив ойлгохуйн үндсэн дээр л боломжтой болно.

Хайдеггерийн үзэл санааг цааш хөгжүүлж Гадамер герменевтикийг судалгааны илүү түгээмэл философи арга болон ертөнцийг үзэхүй болгох оролдлого хийсэн юм. Ойлгохуйг Гадамер уламжлалт байдлаар зөвхөн хүний үйл ажиллагааны баримт гэж биш

⁷⁹ Heidegger M. Being and Time. N.Y., 1962. p.153

харин Хайдеггерийн адил *ертөнц дэх ахуйн суурь арга* гэж үзэв. Ойлгохуй нь ямагт соёл, байгалийн шинжлэл, шинжлэх ухаан, амьдралд нэг үгээр хаана ч гэсэн түүхийн болон хэл шинжлэлийн үйл явц байдаг Дильтей герменевтикийг нийгэм-хүмүүнлэгийн мэдлэгийн арга зүйн үндэс гэдгээр хязгаарлаж байсан бол Гадамер *философийн түгээмэл аспект*⁸⁰ гэж үзэх болсон юм.

Шлейермахер ойлгохуйн категорийг бичвэрийг шинжлэх, Дильтей соёлын феномены хувьд нийгэм-түүхийн үйл явцыг судлахад хэрэглэсэн бол Гадамер амьдралын бүхий л үзэгдэлд хэрэглэх боломжтойд анхаарлаа хандуулсан нь зөв байлаа. Түүнээс гадна Гадамер ойлгохуйн үйл явцын өөрийнх нь түүхэн ба диалектик шинжийг онцолж үзсэн юм. Үүнтэй холбоотойгоор “герменевтик тойрог” Гадамерийн хувьд автономн шинжээ алдаж ойлгохуйн философийн илүү өргөн контекстэд нээгдэж байна. Түүний үзлээр субъектын хүслээр тайлбарлахуй болон манипуляци хийхэд төдийгүй амьдралд оролцох ба хандахад ойлгохуйн түлхүүр оршино. Гадамерийн герменевтик нь ихэнхдээ Хайдеггерийн хэлний болон феноменологийн тайлбарт чиглэсэн байдаг. Гадамерийн хувьд бичвэр нь эцсийн бодит байдал болохдоо үүний л ачаар философийн гол судлах зүйл төдийгүй нууцлаг бие даасан хүч болдог.

Гадамерийн үзлээр бичвэрийн аливаа ойлгохуй нь түүнд байгаа үг, тэдгээрийг холбосон, дамжуулсан утгаас биш, харин ихэнхдээ тайлбарлагч субъектын идэвхит байдлаас хамаарна. Чухамхүү тайлбарлагчаас аливаа ойлгохуйн боломж хамаардаг учраас шинийг бүтээхтэй харьцуулбал өмнөх утгыг тайлах нь тийм ч их идэвхтэй үйл биш юм. Шинэ утгыг бүтээх нь тайлбарлагчийн танин мэдэхүйн гол зорилт бөгөөд тэрээр ойлгохуй ба “ахуйн” хүрээнд ойртохыг эрмэлзэж байгаа тухайн эрин үе ба соёлынхоо тээгч нь болох нийгэм-түүхийн үүрэгтэй юм. Гэхдээ Гадамер өнгөрсөн үеийн болон соёлын утгуудыг “уламжлал” учраас бүрмөсөн хаяж орхиогүй юм. Түүнтэй шинэ тайлбарлагчийн шинэ санаа мөргөлдөж “герменевтик тойргийн” шинэ хувилбар үүсч тэр нь “ойлгохуйг уламжлалын хөдөлгөөн ба тайлбарлагчийн хөдөлгөөний хоорондох тоглоом мэт дүрсэлнэ”⁸¹.

“Герменевтик тойргийн” зохистой утга нь ойлгогдсон бүхэл ба түүний тусламжтайгаар тодотгогдсон хэсгүүдийн хоорондын зөрчил, асуудлын голыг ойлгохуй болон түүний бүхий л агуулгыг хэсэгчлэн тайлбарлахуйн хоорондын гэх мэт зөрчилд оршино. Жишээ нь бид уран зохиол юмуу өөр бичвэрийг агуулгынх нь үүднээс судалж байхад тэр нь хэсгүүдийн цогц, бүхэл бүтэн юм мэт бидний өмнө байна. Чухам энэхүү нийлбэрээр дамжин бүхлийн агуулга нь хэлбэрт харьцана. Гэвч хэлбэр рүү гүнзгийрэхийн хэрээр агуулгын нийлмэл шинж нь илтэд хангалтгүй болж бүхлийг болон түүний онцлогийг илүү гүнзгий ойлгох шаардлага гарч ирнэ. Ийнхүү зөрчлөөр дамжин амжилттай ойлгох үйл явц урагшилна.

Аливаа утга санааг эзэмшигч байгууламжийг, жишээ нь уран зохиолыг бүтцийн хэсгүүдэд хуваах нь онцгой мөн чанар бүхий бүхлийн оршихуйн зайлшгүй нөхцөл болдог. Хэсэг ба бүхлийн харилцан холбоо нь өвөрмөц мөн чанар бүхий тухайн хэсгүүдийн ч оршихуйн зайлшгүй нөхцөл болно. Үүнтэй адил үг бол өгүүлбэрийн момент (буюу хэсэг) өгүүлбэр нь өөрөө зохиолын бүрэлдэхүүнд орон түүний хэсэг (буюу момент) болно гэх мэт. Эдгээр моментыг тасралтгүй харилцаа, тодруулга явагдаж тойргийг өргөтгөж байх тул тойрог гэж нэрлэх нь харьцангуй юм. Энэ нь юуны өмнө ороомог бөгөөд өмнөх тойрог бүр

⁸⁰ Gadamer H.-G. Truth and Method. N.Y., 1975.p.268

⁸¹ Gadamer H .-G. Truth and Method. N. Y., 1975.p.269

нь дараагийнхаа тойргийг өргөтгөж тиймээс анхных нь хаагдаж “амжихгүй”, харин дараагийн илүү өргөн тойрогт шилжиж байж шийдвэрлэгдэнэ.

Герменевтикчдийн ашиглаж байгаа тойргийн дүр зураг нь ойлгохуйн үйл явцын жинхэнэ утгыг гажуудуулдаггүй. Гэхдээ танин мэдэхүй нь ямагт ойлгохуйг өргөтгөж түүний заагаас байнга гаргаж байдаг учраас ойлгохуй нь хэсэг ба бүхлийн харилцааны буюу хаалттай системээр хязгаарлагдахгүй. Түүнээс гадна тойргийн “эвдрэл” гэсэн санаа нь “урьдач ойлгохуй”-гаар дамжин зөвхөн гаднаасаа (метафорически) ойлгохуй ба урьдач ойлгохуйн харилцан шүтэлцээний тойргийн “эвдрэл” мэт санагдана Урьдач ойлгохуйг оруулаад (жишээ нь ойлгохуйн нөхцлийг бүрдүүлэгч шинэ онцгой шаардлагыг оруулаад) бид “герменевтик тойргийн” зарчмыг тэр тусмаа шинэ шинэ утга санаатай болгож ойлгохуйг өргөтгөж байдаг.

“Зохиогчийн ухамсар”, “соёлын дэвсгэр”, “эрин үеийн оюун сэтгэхүй”, “бичвэрийн нууц”, “тайлбарлагчийн далд бололцоо”-нд нэвтрэх буюу тэдгээрийг ухаарах зэрэг герменевтикчдийн авч үздэг ойлголтууд нь шинэ шинэ объектуудыг герменевтик шинжилгээний хүрээнд оруулахад чиглэсэн герменевтикийн шинжлэх ухааны хөгжлийн хандлагыг тусгаж байна. Тийм учраас бичвэр, түүний тайлбар төдийгүй соёлыг бүтээгч бүтээлч сэтгэлгээний аливаа үйл ажиллагаа нь ямар нэг түгээмэл зарчим мэт байгаа герменевтик аргын авч үзэх хүрээнд илэрнэ.

Хүн төрөлхтний амьдралд шинэ үеийнхний оролцох нь ямагт нийгмийн харилцаагаар, өөрөөр хэлбэл соёлын уламжлалаар дамждаг. Гэхдээ соёлын уламжлал гэдэг нь эдгээр соёлыг болон дээж бүтээлүүд, тэдгээрийн агуулга, оюун санааг шинээр босгоно, дахин сэргээнэ гэсэн үг юм. Харин энэ бол “Мастерийн оюуны бүтээлч ажлын нууцыг ажиглах мэт, түүний физик хэмнэл – зогсолт, давшилт, сэргэлт, уналтыг мэдрэн түүнд оролцох мэт, нэгдэл холбоо үүсэх момент, санааны дүр төрхийг барьж авах (“харах”) мэт онцгой ажил юм”⁸².

Соёлын дүр төрхийг барагцаагаар дахин сэргээх, түүнтэй гүнзгий танилцах тухай Испанийн сонгодог зохиолч Б.Грасиан⁸³ бичиж байв. Ингэж танилцах нь өөртөө интуицийн моментыг агуулна, гэхдээ интуици нь мэдлэг дээр тулгуурлах юм.

Чухам ийм л зохистой ухаарагдсан соёлын уламжлал нь бүр хожуу үеийн нийгмийн ахуйн бүрэн бүтэн байдлыг нөхцөлдүүлдэг байна. Бий болсон соёлын бүтээл нь зохиогчоосоо хамааралгүй мэт болж харьцангуй бие даасан байдалтай оршиж, хүрээлэн буй амьдралд идэвхтэй нөлөөлтлөө удаан амьдарч, ямар нэг хэмжээгээр амьдралыг төлөвшүүлж урсгалыг нь тодорхойлж байдаг.

Шинэ үед тийм зохиолуудыг арай өөрөөр тайлбарлаж, өмнө нь ажиглаагүй байсан шинэ утга санааг шинэ нөхцөлд тодруулан гаргаж, урьд хамгийн чухалд тооцогдож байсныг нь үл тоомсорлох болжээ. Бичвэр ба тайлбарлагчийн хооронд тохиолдол бүрт тогтдог утга санааны байнгын, хувиршгүй давталт, ойлгохуйн үйл явцад оролцож байгаа аль болох олон тооны гишүүнээр (утга санаагаар) “тойргийг” дүүргэх, өргөтгөх чиглэл; тайлбарлагчийн уламжлал гэж нэрлэгдэх зүйлийг “эрин үеийн уламжлалтай” харьцуулан холбож үзэх, харин дараа нь тэдгээрийг шинэ зүйлээр эвдэх гэх мэт энэ бүгд нь хэрэг дээрээ “герменевтик тойргийн” мөн чанарыг аргын хувьд бүрдүүлж байгаа юм.

⁸² Керцелли Л. Мир Пушкина в его рисунках, 1820-е годы. М., 1983. с.5

⁸³ Грасиан Б. Карманный оракул. Критикон. М., 1981. с.23

Соёлыг ойлгох эх булаг бол түүнийг бүтээсэн ард түмэнтэй амьд харилцаа тогтоох явдал юм. Зохиогчийн эзэмшиж буй санаа, тэмдэг билэгдлийн шууд утга санаа төдийгүй далд нуугдмал утга санааг, түүний цаана байгаа зохиогч өөрөө ч тодорхой ухамсарлаагүй утга санааг нэг бүрчлэн мэдэрч чадах нь герменевтикээр сэтгэгч тайлбарлагчийн зорилго ба зорилт юм. Үүний хамт тайлбарлагч нь орчин үеийн нөхцөлд тухайн зохиолыг хүлээн авагчдад бичвэрийн (хууч яриа, баримт бичиг гэх мэт) үзүүлэх нөлөө, өөрөөр хэлбэл сонсогчдын үүрэг, сонссон, уншсан зүйлдээ хэрхэн хандаж буй, зохиогч болон бүтээлийг сэргээгчдэд үзүүлэх хариу нөлөө зэргийг харгалзаж үзэх ёстой. Энд “герменевтик тойргийн” бодит бөгөөд бүрэн дүүрэн агуулгатай шинэ хувилбарууд үүсч байна. Бичвэрийн энэ тойрог ба доод үе рүүгээ гүнзгийрэх утгын гурван үе нь хамгийн эхний бичвэрийг бүтээсэн нөхцөл байдалтай харьцалдуулахыг улам бүр шаардаж байдаг. Энэ нь мөн бичвэрийн тойрог болон хүлээн авагчийн орчин, зарим талаар түүнтэй адил юм.

Жишээ нь нэрт судлаач, оросын уншигчдад японы утга зохиолыг анх танилцуулсан Н.И.Конрад бол япон, хятадаас зүгээр л нэг орчуулдаг төдийгүй, чухамдаа тайлбарлагч байлаа. Түүний хувьд өвч адил орчуулга нь бичвэрийн утга санааг гүнзгий ойлгохын илэрхийлэл болж байв. Орчуулгын үйл ажиллагааны арвин баялаг туршлага нь зарим тусгай тохиолдлуудад европын герменевтикчдийн арга барилыг ч давсан гэмээр өөрийн гэсэн аргыг боловсруулахад хүргэжээ. Конрад яруу найргийн орчуулгын хэд хэдэн төрлийг ялгасан юм. Бичвэрийн агуулга, үзэл санааны үндэстний болон нийт хүн төрөлхтний ач холбогдлын хүрээнд байгаа асуудлыг тэрээр нэг боломжит хувилбар гэж үзжээ. Бичвэрийг судлах үедээ орчуулагчийн үзэж туулсан тухайн эрин цаг, түүний бүтээгдэхүүнийг “мэдрэх” нь орчуулгад зайлшгүй хэрэгтэй. Ойлгохуйн шууд өгөгдөл дээр энд эхлэх цэг болох түүхийн баримт төдийгүй түүнд тохирсон шалгуур бүхий судалгааны объектив материал нэмэгдэнэ. “Соёлын тусгаар тойргуудыг түүхийн нарийн шинжилгээнд оруулах нь тойрог тус бүрийн ямар нэг хоёр үзэгдлийг хооронд нь харьцангуйгаар тэнцүүлэхэд хүргэж болох юм”⁸⁴

Зохиолыг тайлбарлахад Конрадын аргыг баримталбал орчуулагч-тайлбарлагч нь зохиолчийн жинхэнэ бие хүнийг, тэр тусмаа хэрэв тэр нь ард түмнийхээ өнгөрсөнд шингэсэн, тэгэхээр соёлыг “тээгч” хүн бол түүнийг байнга авч үзэх хэрэгтэй болно. Мөн тайлбарлагч нь уламжлалыг амьдруулах, уншигчдад орчин цагт нийцсэн хэлбэрээр гэхдээ зориудын ямар ч өөрчлөлтгүйгээр хүргэх үүрэгтэй.

Энд хаа сайгүй эргэх нөлөө (заримдаа хөндлөнгийн), ихэнхдээ “эргэх холбоо” байдаг. Бүр харилцан яриа, түүн дотор дотоод харилцан яриа нь харилцааны хэлбэрийн загвар болох ба түүний жишээн дээр тойрог хэлбэрээр явагдах танин мэдэхүйн бодит зөрчил, хөдөлгөөнийг ажиглаж болно. Энэ харилцан ярианы ач холбогдлын тухай ойлголтыг бүр эрт үед тэмдэглэсэн байна. Харилцан ярианд өмнө нь байсан мэдлэг, туршлагыг шинэтэй, эсрэгээр шинэ мэдлэг туршлагыг урьд байсантай нь ямагт зэрэгцүүлэн тавьдаг. Гэхдээ тухайн тойрог нь эвристик загвар болохгүй юм. Нийгэм-түүхийн байнгын баримт болохын хувьд тэр нь тусгалын ерөнхий диалектик үйл явцын хүрээнд агуулгын тайлбарыг шаардана. Харилцан яриа нь үнэний субъектив ойлгохуй, объектив тайлбар, тодотгол, хөгжил болж чадах ба болох ч ёстой болохоос түүнийг үгүйсгэгч шинжтэй байж таарахгүй шүү дээ.

Бүхлийн ач холбогдол, шүүрэн авсан интуици болон субъектив нотолгоог хэтрүүлэн үнэлэх хандлага нь герменевтикт төдийгүй холизмд ч байдгийг тэмдэглэх

⁸⁴ Конрад Н.И. Избранные труды. Синология. М.,1977.с.588

хэрэгтэй. Тухайн чиглэлийг баримтлагчид бүхлийг илүүд үзэж түүнийг бүрдүүлэгч хэсгүүдийн үүргийг бууруулснаас бүхэл системд ямар замаар шинэ шинж чанар үүсдэгийг зөв ойлгох ямар ч боломжгүй болдог байна. Тэгэхээр нуугдмал интуицид л найдах үлдэж байна.

Интуици нь ерөнхийдөө танин мэдэхүйн герменевтик аргад хэт том байр суурь эзэлдэг. Герменевтик баримтлалд объектыг шууд болон бүхэл бүтнээр нь танин мэдэх арга нь объектын судалгааны үр дүнгийн баталгааны зайлшгүй байдлыг орлодог. Гэхдээ танин мэдэхүйн интуитив хэлбэр нь түүний логик-ойлголтын аппаратын ач холбогдлыг үгүйсгэдэггүй.

Ийнхүү тайлбарлах урлаг, бичвэрийн орчуулга, тайлбар болон үүссэн герменевтик нь ойлгохуйн интуитив философи болон хувирав. Герменевтикч философичийн хувьд ертөнцийн объект бүр тодорхой утгаар “бичвэр”, харин түүний хөгжлийн олон янз байдлыг философиор ухаарах нь интуитив байдлаар “ойлгохуйн” феноменд шингэн уусахаар хязгаарлагдана.

Дүгнэлт

Ойлгохуйн ба танин мэдэхүйн үйл явцыг тодорхойлох олон чухал ойлголт, зарчим, санаануудыг герменевтик философи дэвшүүлэн гаргасны нэг нь дээр үгүүлсэн герменевтик тойргийн тухай ухагдахуун юм. Герменевтик тойрог бол бичвэрийг хэсэг ба бүхлийн диалектикт тулгуурлан ойлгох зарчим юм.

НОМ ЗҮЙ

- Gadamer H.-G. Truth and Method. N.Y.,1975
- Dilthey W. Gesammelte Schriften. B d. VII. — Gxttingen,1968
- Dilthey W. Selected Wrigthings. L.,1976
- Heidegger M. Being and Time. N.Y.,1962.
- Грасиан Б. Карманый оракул. Критикон. М.,1981
- Керцелли Л. Мир Пушкина в его рисунках, 1820-е годы. М.,1983
- Конрад Н.И. Избранные труды. Синология. М.,1977
- Schleiermacher F.D.E .Hermeneutik. Heidelberg,1969
- Шпет Г.Г. Внутренняя форма слова. М.,1927